

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР



5/1/2023

**ТУС ЦАГДААГИЙН ГАЗАРТ  
2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД  
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ,  
ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ**

Улаангом хот

# Танилцуулга

## Нэг. ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ


1.1 Тус Цагдаагийн газарт 2023 оны 04 дүгээр сард иргэн, аж ахуйн нэгжээс 931 дуудлага мэдээлэл хүлээн авч өмнөх сарын үлдэгдэл 41 нийт 972 гомдол, мэдээлэл шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс -319 нэгжээр буюу -24.7 хувиар буурсан.

Гэмт хэргийн шинжтэй 241, зөрчлийн шинжтэй 731 гомдол мэдээллийг тус тус хуулийн хугацаанд шалгасан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Гэмт хэргийн шинжтэй 41, зөрчлийн шинжтэй 37 нийт 78 гомдол, мэдээлэл буюу нийт шалгасан гомдол, мэдээллийн 8.0 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

### 1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацааг харуулбал:




## Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

### 2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Аймгийн хэмжээнд 130 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 24 нэгжээр буюу 22.6 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 80.0 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 22.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөнгөн гэмт хэрэг 117, хүнд гэмт хэрэг 13 бүртгэгдсэн. Хөнгөн хэргийн илрүүлэлт 80.7 хувьтай, хүнд хэргийн илрүүлэлт 75.0 хувьтай.


2.2 2023 оны 04 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг: /нутаг дэвсгэрээр/:



Нийт гэмт хэргийн 81 буюу 62.3 хувь нь аймгийн төвд, 49 буюу 37.7 хувь нь сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 35 нэгжээр буюу 76.0 хувиар өсч, сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 11 нэгжээр 18.3 хувиар буурчээ.


2.3 Бүртгэгдсэн гэмт хэргийн газар нутгаар нь авч үзвэл:



## 2.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



## 2.5 Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:





## 2.6 Бүртгэгдсэн зарим гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:

№	Гэмт хэргийн төрөл		Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт бууралт нэгжээр	Өсөлт бууралт хувиар
			2022.IV	2023.IV		
1	Бүх гэмт хэрэг		106	130	24	22.6
2	Хүний амьд явахын эрхийн эсрэг 10.1-10.6		1	0	-1	-100
	Үүнээс	Санаатайгаар 10.1				
		Болгоомжгүйгээр хохироох 10.6				
		Бусдыг амиа хорлоход хүргэх 10.4	1	0	-1	-100
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7		35	39	4	11.4
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 12.1-12.5		2	4	2	2 дахин
	Үүнээс	Хүчиндэх 12.1	1	3	2	3 дахин
		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 12.2				
		16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх 12.5.2	1	1	Ижил түвшинд	
	Хохирогчийг насны байдлаар	17 хүртэлх буюу хүүхэд хохирсон	1	3	2	3 дахин
		18 дээш насны	1	1	Ижил түвшинд	
5	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13		0	1	1	100
6	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг 14.1-14.9					
7	Эрүүл мэндийн эсрэг 15.1-15.6		1	0	-1	-100
8	Хүүхдийн эсрэг 16.1-16.11					
9	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17.1-17.12		54	68	14	25.9
	Хулгайлах гэмт хэрэг 17.1		10	12	2	20.0
	Дээрэм 17.2					


	Залилах 17.3	11	46	35	4.2 дахин	
	Эд хөрөнгө устгаж, гэмтээх 17.8					
	Хөрөнгө завших 17.4	2	2	Ижил түвшинд		
	Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, мал завших 17.5	2	2	Ижил түвшинд		
	Тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авах 17.7	1	2	1	100	
	Бусдын хөрөнгө устгаж гэмтээх, үрэгдүүлэх 17.11	3	0	-3	-100	
	Мал хулгайлах 17.12	25	4	-21	-84.0	
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 20.1-20.16					
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 23.1-23.7	8	14	6	75.0	
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг 24.1-24.9	3	0	-3	-100.0	
	Үүнээс	Хууль бусаар мод бэлтгэх 24.6				
		Хууль бусаар ан агнуур 24.5	3	0	-3	-100
		Хууль бусаар ашигт малтмал олборлох 24.2				
		Химийн хорт, аюултай/б хууль бусаар эргэлтэнд оруулах 24.3				
13	Тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 27.1-27.11	2	4	2	2 дахин	
14	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28.1-28.19/					

## 2.7 Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг:



## 2.8 Гэмт хэрэг үйлдсэн байдал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 42 буюу 32.3 хувь нь согтуугаар, 15 буюу 11.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 49 буюу 37.6 хувь нь цахим орчинд, 13 буюу 10.0 хувь нь гудамж талбайд, 48 буюу 36.9 хувь нь гэр орон сууцанд тус тус үйлдэгдсэн байна.




## Гурав. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

### 3.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь:

Гэмт хэргийн илрүүлэлт 80.0 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 22.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд илрүүлэлт 40.3 хувь, нийслэлд 39.5 хувьтай байна. Улсын дундажаас 39.7 хувиар их байна.



### 3.2 Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдээгүй 20 гэмт хэрэг:



## Дөрөв. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ


### 4.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 115 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38 нэгжээр буюу 49.4 хувиар өссөн.

Холбогдогчид нь эмэгтэй хүн үйлдсэн 14, хүүхэд үйлдсэн 4 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн.



### 4.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс:

		2022.IV	2023.IV
Гэмт хэрэг үйлдсэн бүх хүн		77	115
үүнээс:	Эмэгтэй	6	14
Нас	15 хүртэлх	2	1
	16-17	2	3
	18-24	12	11
	25-29	17	25
	30-34	14	47
	35-39	12	10
	40-44	10	7
	45-49	5	5
	50-дээш	3	6



## Тав. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ

### 5.1 Хохирсон хүн, хүүлийн этгээд:



Гэмт хэргийн улмаас 129 хүн хохирч, 40 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 23 нэгжээр буюу 21.7 хувиар өссөн, гэмтсэн хүн 4 нэгжээр буюу 11.1 хувиар өссөн байна.

5.2 Учирсан хохирол: Иргэн, хуулийн этгээдэд учирсан 743.2 сая төгрөгийн хохирлын 642.6 сая төгрөг буюу 86.5 хувийг нөхөн төлүүлсэн.

### **Зургаа. ЗӨРЧИЛ**

#### **6.1 Нийт бүртгэгдсэн зөрчил:**

Тус цагдаагийн газарт нийт 9224 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2313 нэгжээр буюу 33.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### **6.2 Бүртгэгдсэн зөрчлийн ангилал:**

Зөрчил гаргасан 8979 иргэн, 0 хуулийн этгээдийг 273813.0 сая төгрөгөөр торгосон. Үүнээс бэлэн бус торгуулиар 8588 зөрчилд 170948.0 сая төгрөгний торгууль ногдуулсан.

77 хүнийг баривчлах, 147 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус ногдуулсан байна.

**0 Хуулийн этгээдэд торгууль ногдуулсан**

**77 Баривчилсан**


**147 Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, торгосон**

**8979 Хүнд торгууль ногдуулсан**

6.3 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа:

10 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20 буюу 66.6 хувиар буурчээ. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 10 буюу 100 хувь нь эрэгтэй хүн байна.

#### **6.4 Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:**



**НЭГТГЭСЭН:**

**МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,**

**ЦАГДААГИЙН ХОШУУЧ**

**М.ОДХҮҮ**